

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/008/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Г СҮХБААТАР СУМЫН ЗАСАГ ДАРГА М.ТЭМҮҮЛЭН ТАНАА Г

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № СЭА-2026/068/КА-ТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар сумын ИТХ-ын “2025 оны тодотгосон төсөв батлах тухай” 38 дугаар тогтоолоор тайлант онд 13,699,835.0 мянган төгрөгийн татварын, 503,400.0 мянган төгрөгийн татварын бус зэрэг нийт **14,203,235.0** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан бөгөөд гүйцэтгэлээр **16,065,602.6** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 113.1 хувиар биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

3

4326050372

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын ОНХО-аар 3,857,233.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч төсвийн тодотголоор гэрээ байгуулаагүй 1,621,951.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээг хасаж баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар сумын Засаг дарга нь тайлант онд 14 зорилт, 239 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.4 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БАТМӨНХ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		5,074,073.6	6,268,529.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	3,348,783.6	4,541,808.8
АВЛАГА	5а, 5б, 6а,6б	1,078,154.9	944,649.3
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	647,135.1	782,071.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		13,885,858.6	15,545,818.7
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	13,885,858.6	15,545,818.7
Газар			17,424.0
Биет хөрөнгө		12,532,562.2	14,212,038.2
Биет бус хөрөнгө	13	1,353,296.5	1,316,357.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		18,959,932.2	21,814,349.6
НИЙТ ӨР ТӨЛБӨР		248,186.5	667,941.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		248,186.5	667,941.9
Өглөг		248,186.5	667,941.9
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		18,711,745.7	21,146,407.7
Засгийн газрын хувь оролцоо		18,711,745.7	21,146,407.7
Засгийн газрын оруулсан капитал		324,958.0	324,958.0
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		324,958.0	324,958.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/		1,076,791.6	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		15,511,858.4	17,708,730.3
Хуримтлагдсан үр дүн		1,705,486.4	3,020,068.2
Өмнөх үеийн үр дүн		(1,320,121.7)	4,788,162.8
Тайлант үеийн үр дүн		3,025,607.1	(1,768,094.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		92,651.3	92,651.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		18,959,932.2	21,814,349.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2025 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	29,709,407.38	36,822,813.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	14,133,316.83	15,555,635.85
110	Орлогын албан татвар	13,553,194.08	14,946,982.04
1100	Хувь хүний орлогын албан татвар	14,205,273.56	15,749,658.29
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(652,079.48)	(802,676.25)
113	Хөрөнгийн албан татвар	283,031.77	262,613.17
118	Бусад татвар, төлбөр, хураамж	297,090.97	346,040.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,984,186.05	21,267,177.16
120	Нийтлэг татварын бус орлого	2,984,186.05	3,039,436.61
122	Тусламжийн орлого		17,502,927.75
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		724,812.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,591,904.51	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	25,555,532.22	37,672,817.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,457,020.66	36,035,750.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,985,834.19	16,115,029.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,008,073.45	2,340,721.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,286.82	345,905.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,087,669.52	2,373,900.36
2104	Хангамж, бараа материалын зардал	87,312.75	87,381.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,938.60	283,795.97
2107	Томилолт, зочны зардал	2,365.80	14,619.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,938,519.33	7,669,352.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,683.50	127,713.69
212	ТАТААС	104,815.20	96,588.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,366,371.27	19,824,132.07
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,098,511.55	1,637,067.08
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,153,875.17	(850,004.43)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	35,189.64	1,232.85
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,163,456.71	919,323.02
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(1,128,267.07)	(918,090.17)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	3,025,608.10	(1,768,094.61)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,235,465.0	92,651.3	(1,320,121.7)	14,007,994.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,235,465.0	92,651.3	(1,320,121.7)	14,007,994.6
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,076,791.6			1,076,791.6
Өмчид гарсан өөрчлөлт	601,351.4			601,351.5
Тайлант үеийн үр дүн			3,025,608.1	3,025,608.1
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,913,308.0	92,651.3	1,705,486.4	18,711,745.7
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	16,913,308.0	92,651.3	1,705,486.4	18,711,745.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(14,702.6)		3,082,676.4	3,067,973.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,898,905.4	92,651.3	4,788,162.8	21,779,719.5
Өмчид гарсан өөрчлөлт	1,134,782.8			1,134,782.8
Тайлант үеийн үр дүн			(1,768,094.6)	(1,768,094.6)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны	18,033,688.3	92,651.3	3,020,068.2	21,146,407.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2025 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	28,350,226.88	35,676,508.98
11	ТАТВАРЫН ОРЛОГО	14,133,316.83	15,555,635.84
110	Орлогын албан татвар	13,553,194.08	14,946,982.04
1100	Хувь хүний орлогын албан татвар	14,205,273.56	15,749,658.29
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(652,079.48)	(802,676.25)
113	Хөрөнгийн албан татвар	283,031.77	262,613.17
118	Бусад татвар, төлбөр, хураамж	297,090.97	346,040.63
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	167,202.81	196,864.67
1181	Газрын төлбөр	129,344.23	119,978.16

1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	543.93	29,197.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,625,005.56	20,120,873.13
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,591,904.49	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,569,311.01	32,063,729.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,569,311.01	32,063,729.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,098,124.54	12,143,009.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,890,523.43	3,783,445.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	465,142.55	611,874.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,552,709.29	2,593,636.21
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	456,389.76	219,735.85
2104	Хангамж, бараа материалын зардал	717,064.99	1,366,096.42
2105	Нормативт зардал	820.30	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	309,763.40	32,311.37
2107	Томилолт, зочны зардал	23,652.80	14,619.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	518,752.32	294,356.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,893.50	127,713.69
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,619,695.46	3,155,870.35
212	ТАТААС	104,815.20	96,588.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,366,371.27	19,824,132.07
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,780,915.87	3,612,778.99
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,837.49	14,560.04
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	3,088,376.05	2,481,013.84
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,088,376.05	2,481,013.84
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,085,538.55)	(2,466,453.79)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	89,479.35	
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	24,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(89,479.35)	46,700.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,605,897.96	1,193,025.19
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	742,885.68	3,348,783.64
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,348,783.64	4,541,808.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,295,433.2	15,789,854.5	2,505,578.7	86.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,895,801.2	13,394,534.2	1,501,267.0	89.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,876,604.7	8,464,557.7	1,412,047.0	85.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,558,141.6	2,340,434.8	217,706.8	91.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	319,767.7	278,387.6	41,380.1	87.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,883,886.9	2,373,900.4	509,986.5	82.3
2104	Хангамж, бараа материалын зардал	121,236.0	86,022.9	35,213.1	71.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	451,811.8	389,990.6	61,821.2	86.3
2107	Томилолт, зочны зардал	42,240.0	14,619.0	27,621.0	34.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	227,407.5	128,279.7	99,127.8	56.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,272,113.2	2,852,922.8	419,190.4	87.2
212	ТАТААС	96,588.4	96,588.4	-	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	96,588.4	96,588.4	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,922,608.1	4,833,388.1	89,220.0	98.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,752,276.1	4,752,276.1	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	170,332.0	81,112.0	89,220.0	47.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,248,432.0	239,532.2	3,008,899.8	7.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	151,200.0	-	151,200.0	-
24	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,295,433.2	15,789,854.5	2,505,578.7	86.0
	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,295,406.7	15,760,172.6	2,535,234.1	86.0
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС САНХҮҮЖИХ	26.5	29,681.9	(29,655.4)	112.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,311,566.2	(3,311,566.2)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,507,281.1	(4,507,281.1)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	124	124	124	100
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	3	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	61	61	61	100
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	61	61	61	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	28,108.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,108.7
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,108.7
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,160.0
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,824.7
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,124.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,108.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,108.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,108.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,108.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,108.7

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн ХХС-ийн зээлийн авлага болон тус ТТЗ-ийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/83 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 12,360,610.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **123,606.1** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан сумын ИТХ-ын тогтоолоор үүсгэн байгуулагдсан “Өргөн сэлэнгэ үйлчилгээ” болон “Цагаан эрэг” ОНӨААТҮГ-уудын санхүүгийн тайлан тус суманд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 37,672,817.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, **367,728.2** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагад ном хэвлэлийн зардал, дүрэмт хувцас худалдаж авахгүй байхад хяналт тавьж ажилласан,
- Албан хэрэг хөтлөлтийг цахимжуулж бичиг хэргийн зардлыг бууруулсан,
- Хөрөнгө оруулалтаар суудлын авто машин, тоног төхөөрөмж, тавилга худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 35 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрч байгууллагын хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.Үүнд:

- Сумын ИТХ нь Япон улсын зочид, төлөөлөгчдөд өгөх 1,338.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлсийг бараа үйлчилгээний бусад зардлаас худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 11. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн тоо	Хугацаа хоцроосон
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	145	144	1
2	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	170	1
3	Сумын Засаг даргын Тамгын газар	171	171	-
4	Бэлчир бүсийн сум дундын Ойн анги	171	168	-
	Нийт дүн	658	656	2

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

Тус ТТЗ-ийн түвшинд нийт мэдээлбэл зохих 658 мэдээллээс 656 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос хэрэгжиж эхэлсэн “Сүхбаатар сумын гудамж талбайд камержуулалт хийх” 385,041.8 мянган төгрөгийн гэрээний дүн бүхий төсөл, арга хэмжээний явцын санхүүжилтийг “Гэрээний тусгай нөхцөл”-д заасан 70 хувиар бус 38,504.2 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.”, ажил гүйцэтгэх гэрээний “Тусгай нөхцөл”-ийн 13 дахь “Гүйцэтгэл ... 70 хувьд хүрэхэд 70 хувийн санхүүжилт, 100 хувьд хүрэхэд үлдээгдэл санхүүжилтийг олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явцын санхүүжилтийг гэрээний “Тусгай нөхцөл”-д заасан хувь хэмжээгээр санхүүжүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 433 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 9,765.6 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт, 358,535.8 мянган төгрөгийн 11 зөрчилд албан шаардлага, 46,115.6 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	4	9,765.6	4	9,765.6	100.0
Албан шаардлага	11	358,535.8	11	358,535.8	100.0
Зөвлөмж	4	46,115.6	4	46,115.6	100.0
Хариуцлага тооцох албан шаардлага	1	-	1	-	100.0
Нийт дүн	20	414,417.0	20	414,417.0	100.0

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан боловч цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа. Иймээс төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулсан алдаа гараагүй болно.

2025 оны сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт **1,771,677.0** мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **797,545.7** мянган төгрөгийн алдааг залруулж, 3,260.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 113,840.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 857,029.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 39,842.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **156,943.6** мянган төгрөгийн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **210,784.6** мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

Үүнээс:

1. Бие даасан дүгнэлт өгсөн ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар:

Сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдэж, бие даасан дүгнэлт өгсөн “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд **Өөрчлөлтгүй**, “Өргөн сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд **Хязгаарлалттай** дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт **1,554,778.4** мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **797,545.7** мянган төгрөгийн алдааг залруулж, 55,948.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 701,284.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **2** зөвлөмж өгсөн.

2. Сумын ТТЗ-ийн түвшний санхүүгийн тайлангийн аудитаар:

Нийт **216,898.6** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,260.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 57,891.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 155,745.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **39,842.2** мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт:

1. Сумын ЗДТГ нь үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан стратегийн команд штабын сургуулилт хийсэн гэх үндэслэлээр албан хаагчдад тогтоосон хувь хэмжээнээс хэтрүүлэн, илүү цагийн нэмэгдэл хөлсөнд 1,056.9 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан *“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”*-ын 3 дахь *“... нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон нэмэгдэл хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тус сумын 1 дүгээр багийн Засаг даргаар ажиллаж байгаад өөр ажилд томилогдсон Б.Амгаланд тус ЗДТГ-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн Б/25 дугаар тушаалаар 504.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх түлээ нүүрсний хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Төрийн одон, “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнагдсан гэх үндэслэлээр сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн Т.Ууганчимэг, 5 дугаар багийн Засаг дарга Ш.Онон, 3 дугаар багийн хэсгийн ахлагч Э.Болор-Эрдэнэ нарт тус бүр 500.0 мянган төгрөгийн, ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Гантулгад 200.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан *“Төрийн албан хаагчид шагнал олгох журам”*-ын 1.7 дахь *“Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх мөнгөн шагналыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. Сумын ЗДТГ нь батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан **4,579.0** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Үндсэн үйл ажиллагааны бус багийн үйл ажиллагааны зардлаас сумын ЗДТГ-ын 8 албан хаагчид 3,979.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгосон,
2. Багийн үйл ажиллагааны урсгал засварын зардлаас 600.0 мянган төгрөгийн цонхны хөшиг худалдан авсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” -ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

2. ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан **46,692.5** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Жил бүр давтагддаг, урьдчилан төлөвлөх боломжтой цас мөсний баярт 18,855.2 мянган төгрөг, хүүхдийн баярт 16,297.8 мянган төгрөг, мал тооллогын зардалд 2,959.5 мянган төгрөг зэрэг нийт **38,112.5** мянган төгрөгийг зарцуулсан,
- 4,200.0 мянган төгрөгийн дрон дагалдах хэрэгсэл, 3,740.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 640.0 мянган төгрөгийн богино долгионы радио гар станц зэрэг нийт **8,580.0** мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь “Энэ журмын 1.1-д заасан “урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан” гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно.”, 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь “ ... , энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар **тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан **5,250.0** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Сумын ИТХ нь цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх зорилгоор 2 иргэнтэй “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулж, гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэсэн тайлан болон холбогдох анхан шатны баримтгүйгээр иргэн Б.Амарзаяад 1,500.0 мянган төгрөг, С.Болдбаатарт 750.0 мянган төгрөгийг олгосон,
- Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас хүүхдүүдэд мэргэжил сонголтын сургалт хийсэн гэх боловч сургалтын тайлан, гэрээ дүгнэсэн акт зэрэг холбогдох анхан шатны баримтгүйгээр 3,000.0 мянган төгрөгийг Сэлэнгийн долгио чуулгад шилжүүлсэн байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр Сэлэнгийн долгио чуулгын бүжигчин Г.Дэлгэрсүрэн, Ч.Энхтуул нар (2024 оны 11 дүгээр сарын 16-нд уран бүтээлийн “Хувиршгүй” тоглолтоо хийсэн) -т тайлант оны Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас 1,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “*Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.3-д “*бүх өр төлбөр*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр тайлант оны батлагдсан төсвөөс дэмжлэг олгохгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5. Бэлчир бүсийн сум дундын Ойн анги нь төлбөр, тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 370.3 мянган төгрөгийн НДШ, ХХОАТ-ын авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2: бүх хөрөнгө, ... авлага*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: Нийт авлагын 75.2 хувь буюу 710,893.4 мянган төгрөгийг ХХС-ийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл эзэлж байна. Үүнээс 658,624.4 мянган төгрөг буюу 92.6 хувь нь 2011-2022 оны хооронд олгосон хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлага байна.

Мөн эзэн холбогдогч нь тодорхойгүй ХХС-ийн зээлийн хүүгийн 67,680.5 мянган төгрөгийн авлагыг 2020 оноос бүртгэл тайланд тусгасан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь “*Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Дээрх хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн авлагыг барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээг зохион байгуулах, эзэн холбогдогч нь тодорхойгүй зээлийн хүүгийн авлагын асуудлыг дээд шатны төсвийн захирагчтай хамтран шийдвэрлэх.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

2.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 88,065.4 мянган төгрөгийн 64 нэр төрөл (Сумын ИТХ нь 18,659.3 мянган төгрөгийн 29 нэр төрөл, ЗДТГ нь 69,406.1 мянган төгрөгийн 35 нэр төрөл) -ийн хөрөнгийг актлах болон цаашид ашиглах эсэх саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дахь “*... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын ТТЗ	4	118,373.0	-	-	3	50,692.5	1	67,680.5	-	-	-	-
Сумын ИТХ	3	21,109.3	1	200.0	1	2,250.0	1	18,659.3	-	-	-	-
Сумын ЗДТГ	4	77,046.0	3	3,060.9	1	4,579.0	-	69,406.1	-	-	-	-
Бэлчир бүсийн сум дундын Ойн анги	1	370.3	-	-	1	370.3	-	-	-	-	-	-
Дүн	12	216,898.6	4	3,260.9	6	57,891.8	2	155,745.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хэрэгжилт								
Сумын ТТЗ	1	38,504.2	-	-	1	38,504.2	-	-
Дүн	1	38,504.2	-	-	1	38,504.2	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт								
Сумын ИТХ	1	1,338.0	-	-	1	1,338.0	-	-
Дүн	1	1,338.0	-	-	1	1,338.0	-	-
Нийт дүн	2	39,842.2	-	-	2	39,842.2	-	-